



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой, 3 нэрийн, нийт 31,820,000.00 (гучин нэгэн сая найман зуун хорин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 25,000,000.00 (гучин сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Оюунбилэг, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хүүхдийн төв номын сан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 269 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

2.4. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001090
15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын... нийн едрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашин нэр, төрөл, Улсын болон арлын дугаар | Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо | Балансын үнэ, хуригтлагдсан элэгдэл (төгрөг) | Цаашид ашиглах хугацаа (жил) | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Автомашин эзэмшигч байгууллагын нэр | Автомашин хүлээн авагч байгууллагын нэр |
|----------|---|--|--|------------------------------|---------------------------------|--|---|
| 1 | Тоёото приус 30 маркийн автомашин ZVW301309394 арлын, 6749ӨМА улсын дугаартай суудлын автомашин | 2010/2010 | 6,660,000.00 | 3 | 6,000,000.00 | Нийслэл дэх Прокурорын газар | Хүүхдийн төв номын сан |
| 2 | Ниссан теана маркийн 8640УКМ улсын, JN1BAUJ32Z0000617 арлын дугаартай суудлын автомашин | 2011/2011 | 12,580,000.00 | 3 | 7,000,000.00 | Багануур дүүрэг дахь Прокурорын газар | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар |
| 3 | Nissan Teana маркийн 2146УКМ улсын, JN1BAUJ32Z0000625 арлын дугаартай суудлын автомашин | 2011/2011 | 12,580,000.00 | 3 | 12,000,000.00 | Сонгинохайрхан дүүрэг дэх Прокурорын газар | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам |
| | | | | | 25,000,000.00 | | |
| НИЙТ ДҮН | | | | | (хорин таван сая) | | |
| | | | 31,820,000.00 | | | | |
| | | | (гучин нэгэн сая найман зуун хорин мянга) | | | | |